



ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ЯАМ

# Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн ХЭМ ХЭМЖЭЭ

Б.Пүрэвжав, ЭМЯ-ны ЭТГ-ын Эрүүл мэндийн ажилтаны ёс зүй, харьцаа,  
хандлага хариуцсан мэргэжилтэн, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн  
хяналтын хорооны нарийн бичгийн дарга

2018-05-22

# Агуулга

- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйтэй холбоотой эрх зүй
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо, хэсгийн хороо

# Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээтэй холбогдох бодлогын баримт бичиг

- Монгол Улсын Үндсэн хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
- Авлигын эсрэг хууль
- Зөрчлийн тухай хууль

# Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, холбогдох бодлогын баримт бичиг

- Хувь хүний нууцын тухай хууль
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль
- Эвлэрүүлэн зуучлалын тухай болон бусад холбогдох хууль
- “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ” Эрүүл мэндийн сайдын 2013 оны 446 дугаар тушаал
- “Дүрэм батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2017 оны 256 дугаар тушаал

# Эрүүл мэндийн тухай хууль

- 26 дугаар зүйл. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг тогтоох, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох,
- 26.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн хяналтын хороо, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дэргэд ёс зүйн салбар хороо ажиллана. Ёс зүйн хяналтын хороо, салбар хорооны үлгэрчилсэн дүрэм болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг эрүүл мэндийн сайд батална.

# Эрүүл мэндийн тухай хууль

- 26.3. Эрүүл мэндийн сайд Ёс зүйн хяналтын хорооны шийдвэрийг үндэслэн эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрчсөн эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар, мэргэжлийн алдаа гаргаж, хүний амь нас, эрүүл мэндийг хохироосон нь зохих байгууллагаар тогтоогдсон бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 1-3 жил хүртэлх хугацаагаар тус тус хүчингүй болгоно.
- 26.4. Ёс зүйн салбар хороо нь эмнэлгийн мэргэжилтний болон анагаах ухааны ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эмнэлгийн мэргэжилтэнд хууль тогтоомжийн дагуу шийтгэл ногдуулах саналыг холбогдох эрх бүхий албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлнэ.

# Эрүүл мэндийн тухай хууль

- 27 дугаар зүйл. Хүний их эмчийн тангараг

"Эмч би, эмчийн ёс зүй, төрийн хуулийг чандлан сахиж, эрдэнэт хүний амь нас, эрүүл мэндийн төлөө эрдэм чадал, энэрэх сэтгэлээ харамгүй зориулахаа тангараглая.

- 28.4.1. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг биелүүлж, хүнлэг, энэрэнгүй үзлийг эрхэмлэн, мэргэжлээ хүний эрүүл мэндийн эсрэг ашиглахгүй байх;

# Нэгдсэн эмнэлэг, түүнтэй адилтгах хувийн хэвшлийн эмнэлгийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт

- 1.11 Ёс зүйн салбар хороотой, үйл ажиллагаа тогтмолжсон байх- 100, 0 оноо
- 2.5. Эрүүл мэндийн ажилтнууд ёс зүйн сургалтад хамрагдсан байх- 100, 0 оноо
- 5.3. Алдаа зөрчлийг бүртгэж, мэдээлдэг, хариу арга хэмжээ авдаг байх- 100, 0 оноо
- 6.1 Байгууллага нь үйлчилгээний соёлыг төлөвшүүлсэн байх- 100, 50, 0 оноо



# Сувилалыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт

- 1.9 Ёс зүйн салбар хороотой, үйл ажиллагаа нь тогтмолжсон байх- 100, 0 оноо
- 2.5 Эрүүл мэндийн ажилтнууд ёс зүйн сургалтад хамрагдсан байх - 100, 0 оноо
- 5.3 Алдаа зөрчлийг бүртгэж, мэдээлдэг, хариу арга хэмжээ авдаг байх- 100, 0 оноо
- 6.1 Байгууллага нь нь үйлчилгээний соёлыг төлөвшүүлсэн байх- 100, 50, 0 оноо

# Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн ХЭМ ХЭМЖЭЭ

**Эмнэлгийн удирдах ажилтан нь ёс зүйн дараах нэмэлт үүрэг хүлээнэ.**

- Хариуцсан нэгж байгууллагын түвшинд уйлчлүүлэгчийн мэдээллийн нууцыг хадгалах, хамгаалах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Эмнэлгийн хязгаарлагдмал нөөцийг шударгаар хуваарилах
- Байгууллагын хэмжээнд ёс зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, ёс зүйн салбар хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.
- Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхээс татгалзсан эмчийн хүсэлтийг хүлээн авч, шалган нэн даруй шийдвэрлэнэ.
- Удирдах ажилтан нь эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үүргээ гүйцэтгэх явцад хөндлөнгөөс оролцох, зааварчлах, тулган шаардахгүй байх



# Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн ХЭМ ХЭМЖЭЭ

- Эмнэлгийн байгууллага, эмнэлгийн бусад мэргэжилтний нэр төр, мэргэжлийн ур чадвар болон үйлчлүүлэгчийн нууцтай холбоотой аливаа мэдээллийг санамсаргүй буюу санаатайгаар хөндлөнгийн хүмүүст ярих, шүүмжлэхгүй байх
- Мэргэжил, мэргэшсэн давуу байдлаа ашиглан эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, саад учруулах, санаатайгаар олноороо эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, стандартыг алдагдуулахгүй байх



# Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн ХЭМ ХЭМЖЭЭ

- Үйлчлүүлэгчийн карт, өвчний түүх, эрүүл мэнд, эмчилгээ, үйлчилгээний талаарх тодорхойлолтыг хуурамчаар үйлдэх, хуурамч бичиг баримтанд гарын үсэг зурах, үйлчлүүлэгчийн эрүүл мэндтэй холбоотой бичиг баримтыг нөхөж бичих, засварлах устгах, хуудас солихгүй.
- Өвчний түүх болон үйлчлүүлэгчийн нууцтай холбоотой бичиг баримтыг үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах буюу ашиглуулахгүй.



# Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн ХЭМ ХЭМЖЭЭ

- Үйлчлүүлэгчид урьдчилан мэдээлж, зөвшөөрөл авахгүйгээр төлөвлөгөөт мэс заслын явцад эмчийг солихгүй байх
- Хэвтэн эмчлүүлэгчид яаралтай тусламж үзүүлэхээс бусад тохиолдолд эмчлэгч эмчийх нь зөвшөөрөлгүйгээр өөр эмч үзлэг хийх, тусламж, үйлчилгээтэй холбоотой зааварчилгаа өгөхгүй байх
- Шаардлагагүй тусламж, үйлчилгээг зааварчлахгүй байх

# Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн ХЭМ ХЭМЖЭЭ

- Үйлчлүүлэгч мэс засал хийлгэсэн эсвэл эмнэлэгт нас барсан тохиолдолд өөрийнх нь болон асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр эд эрхтэний бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй байх, энэ талаар заавар зөвлөгөө өгөхгүй байх
- Үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлэх боломжтой байхад хувийн ашиг сонирхлын үүднээс өөр эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлэхийг албадах, өөр хувилбарыг тулгахыг хориглоно.
- Үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр түүнийг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр танигдахуйц байдлаар харуулах



# Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн ХЭМ ХЭМЖЭЭ

- Үйлчлүүлэгчийг илт төөрөгдүүлж, худал ташаа мэдээлэл бүхий сурталчилгаа явуулахгүй
- Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, үр дүн нь тодорхойгүй, чанарын баталгаагүй эм, эмнэлгийн хэрэгсэл, БИБ-ийг дэмжих, сурталчлах, зарж борлуулах, санал болгох,
- Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байгуулага, эмчээ сонгох эрхээ эдлэхэд хувийн ашиг сонирхлын үүднээс хандаж, нөлөө үзүүлэхгүй байх



# Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн ХЭМ ХЭМЖЭЭ

- Эмнэлгийн мэргэжилтэн нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг эрүүдэн шүүх, тарчлаан зовоох, харгис хэрцгий харилцах, нэр төрийг нь доромжлох, басамжлах аливаа хэлбэрийг нуун дарагдуулах ба өөрөө оролцох
- Эмнэлгийн мэргэжилтэн нь эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлснийхээ төлөө авлига, хууль бус шан харамж, хандив бэлэг, албан бус төлбөр авахгүй байх



# Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 256 дугаар тушаал

- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны бүрэлдэхүүнийг 15 болгон өргөжүүлж, 2 дэд хороотой болсон:
- Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх дэд хороо
- Иргэний өргөдөл гомдлыг шийдвэрлэх дэд хороо

# Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хорооны бүтэц, зохион байгуулалт

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн  
**хяналтын хороо /1/**

Эрүүл мэндийн тухай хуулийн 26 дугаар зүйлд “Эрүүл мэндийн яамны дэргэд Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хянагчдын хороо ажиллана” гэж заасан.

Эмнэлгийн мэргэжилтний  
ёс зүйн **салбар** хороо /46/

Эрүүл мэндийн газар, БОЭТ, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн дэргэд

Эмнэлгийн  
мэргэжилтний ёс зүйн  
**хэсгийн хороо**

Нэгдсэн эмнэлэг, амаржих газар, нийгмийн эрүүл мэндийн төв, сувилалын дэргэд

Эмнэлгийн  
мэргэжилтний ёс зүйн  
**баг**

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн дэргэд

# Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны чиг үүрэг

---

- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах
- Эмч, эмнэлгийн мэргэжилтэн
- Иргэд
- ТВ, хэвлэл мэдээллийн ажилчидтай хамтран ажиллах
- Салбар хороодын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах
- Харьяаллын дагуу иргэний өргөдлийг шилжүүлж шийдвэрлүүлэх
- Шийдвэрт хяналт тавих
- Ёс зүйн зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, арга хэмжээ авах
- Эмнэлгийн мэргэжилтнүүдэд ёс зүйн зөрчилгүй болохыг тодорхойлсон тодорхойлолтыг гаргаж өгөх

# Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны эрх

- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, арга хэмжээ авах
- Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа **эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох** асуудлыг хянан, тогтоол гаргаж, шийдвэрлүүлэх
- Хөдөлмөрийн тухай хуулийг үндэслэн захиргааны шийтгэл оногдуулах саналыг ажил олгогчид тавих
- Сургалтад хамруулах

# Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны үүрэг

- Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сурталчлах
- Ёс зүйн хэсгийн хорооны гишүүдийг чадавхжуулах ажлыг зохион байгуулах
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйтэй холбоотой асуудлаар иргэд, албан тушаалтан, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, бусад материалыг хүлээн авах, хянан судалж хэлэлцэн, шийдвэрлэх

# Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны эрх

- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, хорооны бүтэц, зохион байгуулалт, ажиллах дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж, шийдвэрлүүлэх
- Шаардлагатай бичиг баримтыг холбогдох байгууллага, албан тушаалтан, гомдол гаргагч иргэдээс хүлээн авах, тэдний тайлбарыг сонсох
- Эмнэлгийн мэргэжилтнийг буруугүй гэж үзвэл тэдний эрх ашиг, нэр төрийг хамгаалах, сэргээх
- Үйл ажиллагаандаа тухайн эрүүл мэндийн байгууллагын удирдлага, эмнэлгийн мэргэжилтнүүдээс дэмжлэг авах
- Ажлын урамшуулал авах

# Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо

- Хэсгийн хорооны бүрэлдэхүүнийг хэлэлцэх, батлах, баталгаажуулсан тогтоолын хуулбарыг Хяналтын хороонд хүргүүлэх
- Салбар хорооны дарга, орлогч дарга, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 3 жил
- Салбар хорооны дарга, орлогч даргаар нь тухайн байгууллагын дарга, захирал, орлогч дарга, дэд захирал буюу удирдах албан тушаалтан байж болохгүй
- Салбар хорооны гишүүнийг орлон ажиллахгүй
- Салбар хорооны гишүүн хүндэтгэх шалтгаангүйгээр 3 удаа дараалан хуралдаанд оролцоогүй болон байгууллагын дотоод журмаар сахилгын шийтгэл хүлээсэн бол салбар хорооны гишүүнээс эргүүлэн татах үндэслэл болно.

# ЦААШИД АНХААРЧ АЖИЛЛАХ

---

1. Ёс зүйн салбар хороо, хэсгийн хороодын үйл ажиллагааг эрчимжүүлэх, удирдлагын манлайлалтай холбох, үр дүнгийн гэрээнд тусгах
2. Ёс зүйн зөрчлийн шалтгааныг судалж, хариу арга хэмжээ, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ авах,
3. Ёс зүйг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих,
4. Ёс зүйн хороонд сургалт тогтмол зохион байгуулах, арга зүйгээр хангах, орчинг бүрдүүлж өгөх,
  - Ёс зүйн зөв хандлага, зан үйлийг дэмжсэн,
  - Ил тод, шударга байх,
  - Эмч, эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах



**Санаа зөв бол Заяа зөв**

